

**ЗАСАГ ДАРГА САЙД НАРТАЙ БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН  
НИЙЛҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ.**

2011.03.09

ДАРХАН-УУЛ АЙМАГ

№	АГЕНТЛАГУУД	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	
		ХУВЬ	ОНОО
<b>Тэргүүн шадар сайдтай</b>			
1	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс	100,0	5,0
<b>Шадар сайдтай</b>			
2	Хүүхдийн төлөө хэлтэс	100,0	5,0
3	Онцгой байдлын газар	100,0	5,0
4	Мэргэжлийн хяналтын газар	100,0	5,0
<b>Хууль зүй, дотоод хэргийн сайдтай</b>			
5	Цагдаагийн газар	100,0	5,0
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай</b>			
6	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	99,0	4,95
7	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	99,0	4,95
<b>Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай</b>			
8	Тээвэр, авто замын газар	100,0	5,0
9	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	100,0	5,0
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдтай</b>			
10	Боловсрол, соёлын газар	100,0	5,0
<b>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай</b>			
11	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс	69,0	3,45
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>			
12	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар	100,0	5,0
<b>Эрүүл мэндийн сайд</b>			
13	Эрүүл мэндийн газар	100,0	5,0
<b>Батлан хамгаалахын сайд</b>			
14	Цэргийн штаб	100,0	5,0
<b>Статистикийн хороо</b>			
15	Статистикийн хэлтэс	100,0	5,0
<b>НИЙТ</b>		<b>98,0</b>	<b>4,9</b>

ҮНЭЛГЭЭ НЭГТГЭСЭН:

ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б. БАТБАЯР

ТАНИЛЦСАН:

ТЗУХ-ИЙН ДАРГА

Б. АРЪЯА

# **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА САЙД НАРТАЙ БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН.**

2010.03.09

ДАРХАН-УУЛ АЙМАГ

## **1. СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС.**

Тус хэлтэс нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс нийт 658 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэлээ. Мөн төсөвлөгдсөн төсвийн санхүүжилтээр 16.25 сая төгрөгийн бараа, материал худалдан авах үйл ажиллагааг батлагдсан төсөвт багтаан явууллаа. Өөрийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотой асуудлаар нээлттэй самбар, санг тогтмол ажиллуулж үндэсний 180, олон улсын 44 стандартаар иргэдэд үйлчилж ажиллалаа. Сорилын нэгдсэн лабораторийн үйл ажиллагаа, сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг 4 аймгийн 30 албан хаагчдад танилцуулсан. Баталгаажуулах ажлын эталоны хүрээнд:

- Масс 76
- Цахилгаан 3
- Эзэлхүүн багтаамж 11
- Дулаан даралт 4-ийг батлагаажуулж гэрчилгээ олгосон байна. Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтонд заасан сорилтын шинжилгээний хүрээнд
- Хорио цээрийн 375
- Микробиологи 964
- Хүнсэнд 1079 удаа сорилтын шинжилгээ хийлээ.

## **2. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ХЭЛТЭС.**

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 452 хүүхдийн судалгааг гаргалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг гарган картжуулж тэдэнд чиглэсэн арга хэмжээг салбарын байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байна.

Судалгаанд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 167 хүүхдэд ХХҮХ, Хүүхдийн Төлөө Хэлтэс, хүмүүнлэгийн байгууллагууд хамтран 12.938.0 мянган төгрөг, 6400 долларын эмчилгээ, хувцасны зардлыг санхүүжүүллээ.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлж, эрхийг хамгаалах чиглэлээр “Хүүхдийн хүмүүжил гэр бүлээс эхтэй” зөвлөгөөнийг аймагт 650 иргэдэд зохион байгуулж 9 шилдэг гэр бүлийг шалгаруулан сурталчиллаа. Уг арга хэмжээнд 6000 орчим хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулан Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 887,7 мянган төгрөг, Хүүхдийн төлөө хэлтсээс 615,4 мянган төгрөг зарцууллаа.

Улсын чанартай уралдаан тэмцээнд 174 хүүхдийг оролцуулнаас алтан медаль 86, мөнгөн медаль 28, хүрэл медаль 17 нийт 131 медалыг манай аймгийн хүүхдүүд авсан байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, хөгжүүлэх зэрэг бүхий л чиглэлд зохих арга хэмжээнүүдэд төрийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж хэвшлээ.

### **3. ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР.**

Онцгой байдлын ерөнхий газраас зарласан болзолт уралдаан, аймгаас 2010 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд албан хаагчдын ажлын нөхцөл, нийгмийн баталгааг хангахад зориулан 859.679.107 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийлээ.

Мөн аймгийн бүтээн байгуулалтанд хувь нэмрээ оруулах үүднээс “Миний монгол” хүүхэд, залуучуудын соёл, амралтын хүрээлэнд “Аврагчийн алдар” цогцолборыг Онцгой байдлын албаны өдөрт зориулан албан хаагчдын хандив 12 сая төгрөг зарцуулан бүтээлээ.

Гамшигийн голомтод ажиллах чадавхийг нэмэгдүүлэх тактикийн сургууль 12, тархалтын сургуулийг 144 удаа 156 объектод хийж гүйцэтгэлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гал унтраах тусгай тоноглол бүхий Камаз маркийн автомашинаар хангагдаж, аврах, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөхөн хангалт хийсэн байна. Орон нутагт гамшигийн үеийн нөөцийг найдвартай бүрдүүлэх зорилгоор аймгийн нөөцөд 120 тн, сумдад 200 тн өвсний, нөөцийн бусад төрлүүдээр санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллалаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэгт 90,5%-ийн амжилт үзүүлж “дүүрэн хангалттай” үнэлгээ авсан байна.

Дархан-Уул аймагт шинээр байрлуулсан төрийн хяналтын камерыг ашиглан 78 объект, 124 цэгт гал түймэр, гамшиг ослын дуудлаганд хяналт тавьж ажилласан.

2010 онд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг 796 объект, давхардсан тоогоор 28560 айл өрхөд хяналт шалгалт хийж, галын аюулд хүргэж болзошгүй 7107 зөрчлийг илрүүлж, галын аюулгүй ажиллагааны норм дүрмийг зөрчсөн 15 байгууллагыг 2200,000 төгрөгөөр, 28 иргэнийг 550000 төгрөгөөр нийт 3100000 /гурван сая нэг зуун мянган/ төгрөгөөр торгох захиргааны арга хэмжээ авч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд гарсан объектын болон гал түймрийн тоо, хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад объектын гал түймрийн тоог 5,8%, ой хээрийн түймрийн тоог 66.6%-иар бууруулан гал түймрээс 398,6 сая төгрөгийн хөрөнгийг аварч, аварсан эд хөрөнгө өнгөрсөн оныхтой харцуулбал 42%-иар өссөн байна.

### **4. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР.**

Тайлант хугацаанд 7184 хяналт шалгалт хийснээс нэгдсэн байдлаар хийсэн хяналт шалгалтын тоо 541 буюу 7.5%, хамтарсан хяналт шалгалтын тоо 5536 буюу 77.1%, бие даасан хяналт шалгалтын тоо 1107 буюу 15.4%-ийг тус тус гүйцэтгэж, нийт хяналт шалгалтын 40.4%-д нь акт, албан шаардлага, дүгнэлт үйлдсэн байна.

Хийсэн хяналт шалгалтын 18.7% нь удирдах дээд байгууллагын шийдвэрээр, 7.3% нь тухайн байгууллагын хүсэлтээр, 4.9% нь иргэдийн өргөдөл, гомдлоор хийгджээ.

Холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 198 этгээдэд 18729,0 мянган төгрөгийн торгууль, шийдвэр ногдуулсны 97%-ийг барагдуулан ажиллалаа.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт өмнөх онтой харьцуулахад 5.1%-иар ахисан үзүүлэлттэй байна. Өмнөх онуудад барагдуулаагүй актын үлдэгдэл 85.6 сая төгрөгийг барагдуулсанаас улс, орон нутгийн төсөвт 54.6 сая төгрөг оруулж актын барагдуулалт 14,1%, тайлант хугацаанд ногдуулсан актын төлбөрөөс 1098,1 сая төгрөгийг барагдуулж орон нутгийн төсөвт 66,7 сая төгрөг оруулж актын барагдуулалт 95%, нийт 121,5 сая төгрөгийг улс, орон нутаг, сумын төсөвт оруулж ажиллалаа.

2010 онд санхүүгийн нэг бүрчилсэн хяналт шалгалтаар төсвийн болон төрийн өмчийн 60 байгууллагыг шалгаж аймгийн төсвийн орлогын дансанд нийт 63.2 сая төгрөг барагдуулсан ба шалгагдсан байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах дотоод хяналт сайжирч, төлбөр, зөрчил багассан байна.

## **5. ЦАГДААГИЙН ГАЗАР.**

Иргэдийн амар тайван ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, цаашид цагдаагийн байгууллагын төдийгүй төрийн бүх төрлийн ажил үйлчилгээний шуурхай байдлыг хангахад чиглэгдсэн нэгдсэн сүлжээнд холбох, орчин үеийн техник технологийг орон нутагт нэвтрүүлэн хэрэгжүүлэх зорилгоор “Хяналтын нэгдсэн систем”-ийг байгуулахаар шаардагдах 1.5 тэрбум төгрөгний санхүүгийн асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэн 120 ширхэг хяналтын телекамерыг аймгийн нутаг дэвсгэр дээрх нягтрал ихтэй газруудад суурилуулан 2010.10.17-ны өдөр албан ёсоор нээлтийг хийлээ.

Мөн хяналтын нэгдсэн сүлжээтэй холбогдсон, бүрэн тоноглогдсон 2 автомашиныг Солонгос улсаас худалдан авч ашиглаж байгаа бөгөөд дээрх системийн тусламжтайгаар зөрчил гаргасан 120 тээврийн хэрэгсэл, автомашины эд анги хулгайлсан 1 эрүүгийн хэргийг үйлдэл дээр нь илрүүлж, 4 эрүүгийн хэргийн сэжигтнийг камераар баримтжуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд Цагдаагийн газар нь 1307 гомдол, мэдээлэл хүлээн авч шалган шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал гомдол мэдээлэл 27 буюу 2,0% буурсан, хүлээн авсан бүх гомдол мэдээллийн 670 буюу 51,2%-д эрүүгийн хэрэг үүсгэн, 562 буюу 42,9%-ийг харъяаллын дагуу шилжүүлэн 28 буюу 2.1%-ийг нэгтгэн шалгаж шийдвэрлэсэн байна. Хүлээн авсан гомдол мэдээллийн 34.0%-ийг хуулийн анхны хугацаанд, 64,2%-ийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэлээ.

2010 онд тус аймагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрх бүхий 15 байгууллагыг Архидан Согтуурахтай Тэмцэх Тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн дагуу 3369,000₮, 30 иргэнийг 1050000₮ нийт 4419000 төгрөгөөр торгож, архи 287 л, дарс 119 л, пиво 206 л, виски 8 литрийг хураан холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүллээ.

2010 онд гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 134 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеээс 2,1%-иар буурчээ.

Тайлант хугацаанд 12520 зөрчил бүртгэгдсэнээс зөрчил гаргасан 11782 иргэн, 30 байгууллага, аж ахуйн нэгжид 67503996 төгрөгөөр торгож, 494 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 214 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулжээ. Зөрчлийн улмаас хохирсон 140 иргэнд 5367810 төгрөгний хохирол учирснаас 5118110 төгрөг буюу 95,3%-ийг нөхөн төлүүлсэн байна.

## **6. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Аймгийн хэмжээнд байгалийн ус ашигласны төлбөрт 66447,3 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 180771,3 мянган төгрөгийн төлбөр төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 3 дахин давуулан биелүүлсэн дүнтэй байна.

Төсвийн орлогын бүрдүүлэлтээр өөрийн орлогын төлөвлөгөө 200,0 мян.төг оруулахаас 367,5 мян.төг оруулж төлөвлөгөөгөө 183,8 %-иар давуулан биелүүлсэн. БОАЖЯамнаас хөрөнгө оруулалтын санхүүжилтээр нийт 33,6 сая төгрөг, үүнээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд /ойжуулалт ойн арга хэмжээнд 19,6 сая, булаг шандын эхийг хашиж хамгаалахад 14,0 сая төгрөг/ санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан.

Орон нутгийн телевизүүдээр байгаль орчны талаарх хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, танилцуулгыг 18 удаа, 4 төрлийн реклам, шторкыг хийлгэж өдөр 8 удаагийн давтамжтайгаар нийт 64 удаа сурталчиллаа.

Ойжуулалтын ажлын гэрээний дагуу санхүүжилт болох 6.6 сая төгрөгийг иргэдийн нөхөрлөл, ТББайгууллагад олгож нийт 55 га газарт ойжуулалт, үрийн талбай тусгаарлах ажлыг гүйцэтгэж амьдралтын хувь дунджаар 85 %-тай, жилийн өсөлт 5-6 см байна.

Аймгийн хэмжээнд 2009-2010 онд байгуулагдсан 22 нөхөрлөлийн нийт 35481 га талбайд улсын төсвийн хөрөнгөөр ой зохион байгуулалтын ажлыг ойн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Тус аймгийн Байгаль хамгаалах санд тайлант хугацаанд хууль бусаар байгалийн нөөц ашигласан нь тогтоогдсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад тооцсон экологийн нөхөн төлбөр нийт 961,4 мян.төг орсноос байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сурталчилах арга хэмжээнд нийт 480.7 мян.төг зарцуулсан байна.

## **7. УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА.**

Тус алба нь 2010 онд цаг агаарын урьдчилсан мэдээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор [www.tsag-agaar.mn](http://www.tsag-agaar.mn) сайтанд мэдээллийг өдөр бүр шинэчлэн тавьж сумдын ЗДТГ-уудад уг мэдээллийг тогтмол хүргүүлэн ажилласан.

Шинжилгээний ажлын технологийг мөрдөн ажилласан бөгөөд Уур амьсгалын шинжилгээ 99,6%, Нарны цацраг судлал 99.1%, ХАА-н цаг уур 99.8%, Ус судлал 97.9%, Байгаль орчны шинжилгээ 99,9%, Багаж хэмжил зүй 99%, Систем сүлжээ 99%, Урьдчилан мэдээлэх 93.4%, Архив мэдээллийн сан 100%-ийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын барилгыг 290.0 сая төгрөгөөр бариулж, 145.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

## **8. ТЭЭВЭР, АВТО ЗАМЫН ГАЗАР.**

Аймаг, сум, хот хооронд, хот доторхи нийтийн тээврийн 39 чиглэлд 622 тээврийн хэрэгсэл ажиллаж 6019,6 мянган зорчигч тээвэрлэн 3666,0 мян.төг-ийн үйлчилгээг иргэдэд үзүүлээ. Нийт зорчигч тээвэрлэлтийн 88.6%-ийг хотын доторх тээвэрлэлт эзлэж байна. Дархан-Уул аймгаас Архангай, Сэлэнгэ аймгийн Мандал сумын чиглэлд зорчигчдын эрэлт хэрэгцээг хангаж замын нөхцөл байдлыг харгалзан бага оврын автобус явуулах үйлчилгээг шинээр нээлээ.

2010 онд орон нутгийн харъяалалтай 3664 тээврийн хэрэгслээс орон нутгийн авто зам ашигласны төлбөрт 36000.0 мян.төгрөг хурааж орон нутгийн авто замын санд төвлөрүүлсэн нь 2009 оныхоос 10000.0 мян.төгрөг буюу 28%-иар илүү байна. Мөн 2010 онд тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо урьд оныхоос 20.6% өслөө.

2010 онд орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 222.999.000 төгрөгийн зам засварын ажил хийж гүйцэтгэлээ.

Тээвэр, авто замын газар нь улсын төсвөөс 65 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 42 сая төгрөгийн батлагдсан төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд өр авлага үүсгээгүй байна.

Тээврийн үйлчилгээний хяналт шалгалтаар нийт 259 зөрчил илрүүлснээс 163 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 134 иргэнд 2220.0 мян.төгрөг, тусгай зөвшөөрөлгүй 88 тээврийн хэрэгсэлд 1785,0 мян.төгрөгийн торгууль шийтгэвэр ногдууллаа.

## **9. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР.**

Газрын төлбөрийн программ LANDMANAGER-ээр 2010. 01.01-ний өдрөөс эхлэн шинээр нэвтрүүлэн ажиллаж байна.

Газар өмчлөлийн хууль хэрэгжихээс өмнө газар эзэмшиж байсан иргэн, хуулийн этгээдийн хашааны газрыг өмчлүүлэх ажлыг эрчимжүүлснээр газар эзэмшигч, ашиглагчдын 99.0%-ийг улсын бүртгэлд хамааруулж нэгж талбарын дугаар олгон кадастрын зурагт оруулж, бүртгэлжүүлэн өмчлүүлээд байна.

Германы GTZ төсөлтэй хамтран 2010.01.01-ээс эхлэн газрын мэргэжилтнүүд дурын компьютер дээрээс <http://192.168.0.20/darkhangis/map.phtml> вэйб хаягаар газрын кадасмтрын зургийн өөрчлөлт болон нэгж талбарын талаарх мэдээллийг харах боломжтой болсон. QuantumGIS, LANDMANAGER, ArcGis9.3, pgAdminIII програмуудыг нэвтрүүлж сервирт мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна.

Жилийн санхүүгийн тайлан тэнцлийг олон улсын стандартад нийцүүлэн хөтөлж, байгууллагын тооллогын комисс томилж Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого байдлаар улсын төсвөөс 48520.9 мянган төгрөгийн санхүүжилт, ГХБГЗЗГ-аас хөрөнгийн санхүүжилтээр 2352.7 мянган төгрөгийн материалыг орлогод авч дансанд тусгав.Үйл ажиллагааны орлогоор 4788.3 мянган төгрөгийн орлого олж улсын төсөвт 4287.8 мянган төгрөгийг төвлөрүүллээ.Газрын төлбөрийг бүрэн барагдуулах зорилгоор төлбөрийн өртэй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж гэрээг дүгнэн нийт 375 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.Тус аймагт 2010 онд 91093 иргэн, 18961 өрх, гэр бүл бүртгэгдсэн бөгөөд аймгийн хэмжээнд 6885 иргэн, гэр бүлд газар өмчлүүлсэн нь одоогийн байдлаар 29.27%-тай, нийт гэр хорооллын 77.0% нь газраа өмчилж авсан байна.

## **10. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ГАЗАР.**

Тус аймгийн 15 дугаар сургууль, 18 дугаар цэцэрлэгт нийт 243.0 сая төгрөгийн барилгын их засварын ажил, Оюуны-Ирээдүй, Залуучууд театрын дээвэр, 15, 23 дугаар цэцэрлэгийн сан техник, 13 дугаар цэцэрлэгийн дээврийн засварт улсын төсвийн хөрөнгөөр

Нийт 469.0 сая төгрөгийн их засварын ажил хийлээ. Гадаад эх үүсвэрээр нийт 927.0 сая төгрөгийн өртөгтэй сургалтын тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. 2010 онд нийт 1 тэрбум 639 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Улсын төсвийн 98,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Залуучууд театрт гэрэлтүүлгийн болон дуу авианы тоног төхөөрөмжийг шинэчилсэн нь үйлчилгээний чанар ихээхэн нөлөөллөө.

2010 онд аймгийн Музейн сан хөмрөгт шинээр худалдан авах үзмэрийн зардалд 3364.5 мян.төгрөг зарцуулж 10 нэрийн 36 ширхэг үзмэрээр сан хөмрөгөө баяжууллаа.

Аймгийн номын сангийн номын фондонд шинээр ном худалдан авахад 2532,0 мян.төгрөг зарцуулж, номын санг автоматжуулан 2600 нэр төрлийн 10000 гаруй номыг программд оруулж орчин үеийн жишиг номын санг бүрдүүллээ.

## **11. ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС.**

Тус хэлтэс нь 2010 онд нийт 1760 иргэнийг ажлын байранд зуучлахаар төлөвлөснөөс 1967 иргэнийг ажлын байранд зуучилж, зуучлагдсан иргэдийн 70% буюу 1377 иргэн байнгын ажлын байраар, 835 иргэн түр ажлын байраар хангагдсан байна.

Иргэдэд мэргэжил олгох, давтан сургах чиглэлээр мэргэжлийн ур чадварын шалгалтыг зохион байгуулж суралцагчдын 40.7% \163 хүнд\ улсын хэмжээнд баталгаажсан мэргэжлийн үнэмлэх олголоо. Мэргэжил олгох сургалтанд суралцаж байгаа иргэдэд унаа, хоолны зардалд 15150,0 мян.төгрөг зарцууллаа.

НХХЯамнаас зарласан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнесийг дэмжих төсөлд 19 төслийн 56,000,0 мянган төгрөгийн төслийн санхүүжилтийг хийсэн.

Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногоо тариалахаар хүсэлт гаргасан 53 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 136,9 сая төгрөгийн зээл олгож 137 ажлын байр шинээр бий болгосон.

Аймгийн хэмжээнд 95669 иргэн хүний хөгжил сангийн дэвтрээ бичүүлсэнээс 92017 иргэн нь хүний хөгжил сангаас 70,0 төгрөг, 51217 иргэн сар бүр олгодог 10,0 төгрөгийг тус тус авсан байна.

Санхүү, хөрөнгийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд нийт 777812,1 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, ОНОТХҮ-ний төсөл хэрэгжүүлэхэд 89696,2 мянган төгрөгийн санхүүжилт зарцууллаа.

## **12. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР.**

Аймгийн өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өрхийн тариаланг өргөжүүлэх чиглэлээр 1000 өрхөд сортын төмсний үр болон хүнсний ногооны үрийг олгон тариалуулах, 50,0 %-ийн хөнгөлөлттэй нөхцлөөр 100 хүлэмжийг 4 суманд олгуулан хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдамжаар бүрэн ханган ажилласан.

2009-2010 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор цаг үеийн ажлуудыг шуурхай зохион байгуулсан ба малчдад туслах уриалга гарган нийт 76,8 сая төгрөгийн эд хөрөнгө, бараа материалыг малчдад хуваарилан хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд хорогдсон малын сэг зэмийг устган ариутгал халдваргүйтгэл хийх ажилд сумд мэргэжлийн болон хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэн 37,1 мянган толгой малын сэг зэмийг зохих журмын дагуу устгасан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах 311 төслийг хүлээн авч мэргэжлийн албадуудаар төсөл бүрийг хянан үнэлгээ хийж зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комисст хүргүүлсэнээр 2010 онд 95 төсөлд 887,07 сая төгрөгийн зээлийг олгуулж, төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд 263 ажлын байр шинээр бий болж, шинээр 8 үйлдвэр байгуулагдах нөхцлийг бүрдүүллээ.

Атрын 3 дахь аян тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд аяны 3 жилийн хугацаанд нийт 17 аж ахуйн нэгж, 9 иргэнийг газар тариалангийн үйлдвэрлэлийн үзүүлэлтээр шалгаруулан, шагнаж урамшуулах ажилд аймгийн төсвөөс нийт 11,1 сая төгрөгийг зарцууллаа.

Аймгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй гурилын үйлдвэрүүд 2010 онд аймгийн дундаж хүн амын жилийн гурилын хэрэгцээг 158,0%-иар хангах хэмжээний 12253,4 тонн гурил үйлдвэрлээд байна. 2011 оны гурилын хангамжийг бүрдүүлэхээр 6 гурилын үйлдвэрт нийт 9940,8 тонн буудай хүлээн аваад байгаа нь дотоодын үйлдвэрлэлээр аймгийн хэрэгцээгээ бүрэн хангах боломжийг бүрдүүллээ.

2011 оноос эхлэн 1,0 мянган тонн мах бэлтгэх, нөөцлөх, борлуулахаар Засгийн газрын тогтоолын дагуу бэлтгэл ханган ажиллаж Дархан meat фүүдс ХХК хэрэгжилтийг хангахаар санал оруулж, тус үйлдвэрийн хөргөлттэй агуулахад 700 тонн үхрийн мах, Улаанбаатар хотын Номин компаны агуулахад 300 тонн бог малын мах бэлтгэн нөөцлөөд байна.

### **13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР.**

Улсын хэмжээнд анх удаа хөдөө орон нутагт суурилуулсан вирус судлалын молекул Генетикийн лабораторын үйл ажиллагааг эхлүүлж энэ хугацаанд нийт 306 шинжилгээ хийж, томуу, элэгний В, С вирус тоолон, В хүрээний вирус 38, НЗИ2 нэгийг тус тус илрүүлжээ.

Хүн амын бие бялдрын хөгжлийн төвшинг тогтоох Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу нэг сарын хугацаанд 12,000 хүн хамруулж үр дүн гарган улсад нэгдүгээр байр эзлэн өргөмжлөл хүртсэн.

2010 онд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжаар 561,875,353 төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэг авсан байна.

Эрүүл мэндийн газар нь сум, өрхийн эмнэлэгүүдийг нийт 25,630,000 сая төгрөгийн багаж хэрэгслээр хангаж, өөрийн орлогоор 1,211,000 төгрөгийн тохижилтын ажил хийсэн.

Нэгдсэн эмнэлэгийн лавлагаа, хүлээн авах тасагт 15 сая төгрөгийн засвар хийж, өрхийн 5 эмнэлэг, 3 сумын эмнэлэг, Нэгдсэн эмнэлэгийн 18 тасагт өөрсдийн хүчээр дотоод урсгал засварыг хийж 57 сая төгрөг зарцууллаа.

Үйлчилгээний чанарын хөгжлийг дэмжих зорилгоор “чанарын тэмдэг” 1, 2, 3-ыг олгох журмыг хэрэгжүүлж нэгдүгээр улиралд “чанар 1” тэмдгээр 13, хоёрдугаар улиралд “Чанар 1” тэмдгээр 8, “Чанар 2” тэмдгээр 1, гуравдугаар улиралд “Чанар 1” тэмдгээр 1, Чанар 2” тэмдгээр 2 нийт 25 эмч, сувилагч шагнагдлаа.

2010 онд эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх тендерийг нээлттэй зарлаж, 21 эм ханган нийлүүлэх байгууллага оролцож, 11 эм ханган нийлүүлэх байгууллага 13 багцын эм, эмнэлэгийн хэрэгслийг нийлүүлэхээр гэрээ хийгдсэн. 2010 онд нийт 433,6 сая төгрөгийн эм, эмнэлэгийн хэрэгсэл нийлүүлж, харъяа нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлэгүүдэд олгосон.

Нийт 657911 үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт 301119 буюу 45,8 хувь нь хамрагдсан байна.

### **14. ЦЭРГИЙН ШТАБ**

2010 онд цэргийн жинхэнэ албаны татлагаар цэргийн насны залуучуудын 80,3% нь хамрагдаж хугацаат цэргийн албанд татан нийлүүлэх болон гэрээт цэргийн албанд элсүүлэх ЗХЖШтабын даалгаварыг 100% биелүүллээ. Цэргийн насны эрчүүдийн анкетын хөтлөлтөнд үзлэг явуулж, 800 гаруй цэргийн үүрэгтэнд шинээр үнэмлэх олгох ажлыг зохион байгууллаа.

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд бүртгэгдвэл зохих иргэдийн 78,2% нь хамрагдаж, цэргийн шилжилт хөдөлгөөний бүртгэлээр 456 цэргийн үүрэгтэн тус аймгаас өөр аймаг хотуудад шилжиж явсан ба 72 хүн өөр аймгаас шилжиж ирсэн нь бүртгэгдсэн байна. Цэрэг татлагын товчоогоор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ороогүй 761 цэргийн үүрэгтнийг Цэргийн штабын даргын тушаалаар торгож 9,8 сая

төгрөгийг төрийн сан банкинд төвлөрүүлсэн байна. Мөн цэргийн алба хаагаагүй 43 иргэнээр 8,8 сая төгрөгийн мөнгөн төлбөр төлүүллээ.

Тайлант хугацаанд цэргийн дүйцүүлэх алба хаагчдын сургалтыг 2 удаа тус бүр 14 хоногийн сургалтыг зохион байгууллаа.

## **15. СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

Мэдээ тайланг хүлээн авах, шалгах, нэгтгэх, кодлох шиферлэх ажлыг зорилт дэвшүүлэн ажилласнаар үр дүнд хүрч байна.

2010 онд графикаар өгөгдсөн бүх төрлийн Статистик мэдээллийг аймгийн 4 сум, 24 багийн хэмжээнд зохион байгуулан явуулж, нийт мэдээлэгчидтэй 100 % харилцан, тэдгээрийн мэдээллийг хугацаанд нь цуглуулах, шалгах, нэгтгэх ажил зохих ёсоор хийгдэж, аливаа зөрчилгүй 100% дамжууллаа. Статистикийн хэлтсээс болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад этгээдээс худалдан авах бүтээгдэхүүнийг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийг үүнээс аймгийн төсвөөс 2010 онд явагдсан хүн ам, орон сууцны тооллогын ажлыг санхүүжүүлэх зардлыг аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүллээ.

2010 онд нийт 4 сум, аж ахуйн нэгж болон өрхөд статистик мэдээлэл тооллогын бодит байдал, чанарт мониторинг хийх шалгах, зөвлөгөө өгөх ажлыг хийлээ. Мөн багуудад статистик мэдээллээ өгөхөд шуурхай байдалд хэвшүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:  
ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б. БАТБАЯР

ТАНИЛЦСАН:  
ТЗУХ-ИЙН ДАРГА

Б.АРЪЯА